



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 672

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон 26 нэр төрлийн 12,981,633.00 (арван хоёр сая есөн зуун наян нэгэн мянга зургаан зуун гучин гурван төгрөг) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Э.Тэгшжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж устгах, данснаас хасах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг журмын 8 дахь заалтын дагуу 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

000122



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 16 ны өдрийн
58х дугаар тогтоолын хавсралт

"ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Жингийн ширээ	1974/12/31	Ширхэг	3	42,000.00	126,000.00	126,000.00	-
2	Купляцын зуух	1997/12/31	Ширхэг	1	3,602,240.00	3,602,240.00	3,602,240.00	-
3	Магнитэн холигчтой плиткы	1997/12/31	Ширхэг	1	400,050.00	400,050.00	400,050.00	-
4	Спектрофотометр микропринтрийн хамт	2006/12/31	Ширхэг	1	2,335,830.00	2,335,830.00	2,335,830.00	-
5	Удирдлагатай плитка	1997/12/31	Ширхэг	1	96,312.00	96,312.00	96,312.00	-
6	Шаровая мельница	1974/12/31	Ширхэг	2	322,200.00	644,400.00	644,400.00	-
7	Шигших машин	1997/12/31	Ширхэг	1	484,770.00	484,770.00	484,770.00	-
8	Шулуутгагч	1986/12/31	Ширхэг	1	40,000.00	40,000.00	40,000.00	-
9	Экспрессфотометр	1992/12/31	Ширхэг	1	168,000.00	168,000.00	168,000.00	-
10	Вентилятор 2	1988/12/31	Ширхэг	1	36,000.00	36,000.00	36,000.00	-
11	Вентилятор 2	1988/12/31	Ширхэг	1	194,000.00	194,000.00	194,000.00	-
12	Вентилятор 4	1988/12/31	Ширхэг	1	333,000.00	333,000.00	333,000.00	-
13	Жингийн ширээ	1974/12/31	Ширхэг	2	42,000.00	84,000.00	84,000.00	-
14	Вентилятор 3	1990/12/31	Ширхэг	1	240,000.00	240,000.00	240,000.00	-
15	Вентилятор 4	1988/12/31	Ширхэг	1	246,720.00	246,720.00	246,720.00	-
16	Вентилятор 4	1989/12/31	Ширхэг	2	342,460.00	684,920.00	684,920.00	-
17	Вентилятор 4	1989/12/31	Ширхэг	1	408,460.00	408,460.00	408,460.00	-
18	Вентилятор 4	1988/12/31	Ширхэг	5	72,461.00	362,305.00	362,305.00	-
19	Вентилятор 5	1998/12/31	Ширхэг	1	1,370,000.00	1,370,000.00	1,370,000.00	-
20	Биокулярь	1974/12/31	Ширхэг	1	30,000.00	30,000.00	30,000.00	-
21	Нүхлэгч машин	1992/12/31	Ширхэг	2	45,313.00	90,626.00	90,626.00	-

22	Талст гаргах машин	1992/12/31	Ширхэг	1	360,000.00	360,000.00	360,000.00	-
23	Гидроциклон	1975/12/31	Ширхэг	1	48,000.00	48,000.00	48,000.00	-
24	Комбинированная дробилка	1975/12/31	Ширхэг	1	500,000.00	500,000.00	500,000.00	-
25	Биокуляр	1974/12/31	Ширхэг	1	30,000.00	30,000.00	30,000.00	-
26	Флотомашин	1974/12/31	Ширхэг	1	66,000.00	66,000.00	66,000.00	-
Нийт дүн					11,855,816.00	12,981,633.00	12,981,633.00	-
					36	(арван хоёр сая есөн зуун наян нэгэн мянга зургаан зуун гучин гурван төгрөг)		